



Төсөл

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН АШИГЛААГҮЙ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС ХЭРЭГЖИЛТ УДААШИРЧ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА.



АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Улаанбаатар хот
2024 он

Аудитын тайланг**бэлтгэсэн:**

Нийслэл дэх Төрийн
аудитын газар
Гүйцэтгэл-нийцлийн аудитын
хэлтэс

Товчилсон үг

3

Хэлтсийн дарга:

Э.Мөнхмандах

Аудитын зорилт, хамарсан хүрээ,
арга зүй, стандартын талаарх
мэдэгдэл

4-5

Аудитын менежер:

Ерөнхий мэдээлэл

6

Б.Номинбаатар

Ахлах аудитор:

Б.Билэгт

Бүлэг 1.

Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгийг холбогдох хууль журамд
заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж,
хуваарилсан эсэх.

7-13

Аудитор:

М.Одгэрэл

О.Оргил

Б.Батбилгүүн

М.Номин-Эрдэнэ

Бүлэг 2.

Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга
хэмжээг журмын дагуу үр дүн, үр
нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх.

14-20

Бүлэг 3.

Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгийн зарцуулалтыг хууль
журмын дагуу хянаж, тайлагнасан
эсэх

21-26

Аудитын дүгнэлт

27

Аудитын зөвлөмж

28

Хаяг: УБ хот, Сүхбаатар
дүүрэг, Соёлын Төв өргөө
Г корпус. Утас: 327787
Тайланг <https://audit.mn/> веб
сайтаас үзнэ үү.

Хавсралтууд

29-35

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ДОНХС	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МУЗЗНДТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НД	Налайх дүүрэг
НДАГ	Нийслэлийн дотоод аудитын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НОНХС	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
СБД	Сүхбаатар дүүрэг
СС	Сангийн сайд
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УМС	Удирдлага мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭЗТХ	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн Аудитын газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад НЗДТГ-ын СТСХ, ХБТХ, 9 дүүргийн ЗДТГ-ын ДБТХ, СТСХ, ЭЗТХ, ХААА зэрэг хэлтэс, албадыг хамруулан ОНХС-ийн 2023 оны төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, өмнөх онуудаас дамжин хэрэгжих болон шинээр эхлэх ажлуудын санхүүжилт, гэрээний хэрэгжилтийг түүвэрлэн хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг Төрийн Аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим” MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020, “МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитад Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХ, Барилгын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон МУ-ын ЗГ-ын 2016 оны 153, 2017 оны 230 дугаар тогтоол, СС-ын 2012 оны “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”, нийслэл, дүүргийн ИТХ, ЗД-ын тогтоол, захирамж, шийдвэр холбогдох бусад эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болголоо.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Билэгт аудитор, М.Одгэрэл, О.Оргил, Б.Батбилгүүн, М.Номин-Эрдэнэ нар гүйцэтгэв. Аудитыг 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв.
Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл	Тус аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн дэд хөтөлбөрийг 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлуулж, гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 6 дугаар сарын 18-ний өдөр хүртэл буюу ажлын 18 өдрийн хугацаанд аудитыг гүйцэтгэсэн нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн 2023 оны хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 2023 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйл, СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын /цаашид ОНХС-ийн журмын гэх/ 8.8-д заасны дагуу өмнөх оны үлдэгдэл санхүүжилтээр 20,488.4 сая төгрөг, ОНХНС-ийн шилжүүлэг 40,715.6 сая төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээс 204.7 сая төгрөг, нийт 61,408.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

НОНХС-ийн орлогын хэмжээг Төсвийн тухай хуульд заасны дагуу НИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 02/11 дугаар тогтоолоор баталж, 2023 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн 115 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 45,048.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 243 ТАХ-г төлөвлөжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 61,623.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 513 ТАХ-ээс 286 ТАХ буюу 55.8% хэрэгжсэн, 126 ТАХ буюу 24.6% дутуу хэрэгжсэн, 103 ТАХ буюу 20% хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 1. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН ЭСЭХ.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулсан боловч хуульд заасан эх үүсвэрээр төлөвлөж бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй, зөвхөн ОНХНС-аас шилжүүлсэн орлогыг хуваарилжээ.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэрээр бүрэн төлөвлөөгүйгээс бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй, ОНХНС-аас НОНХС-д, НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?

2023 онд нийслэл, дүүргийн ОНХС-ийн орлогыг 3 төрлийн эх үүсвэрээс нийт 61,408.8 сая төгрөг бүрдүүлснээс өмнөх оны үлдэгдэл 20,488.4 сая төгрөг, ОНХНС-ийн шилжүүлэг 40,715.7 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 204.7 сая төгрөг байна.

Хүснэгт №1. ОНХС-ийн эх үүсвэр

/мянган.төг/

№	Нэр	Нийт санхүүжилт	Үүнээс		
			Өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-ийн шилжүүлэг	Малын тоо толгойн албан татвар
1	Баянгол	2,289,555.8	303,480.7	1,986,075.1	-
2	Баянзүрх	7,118,495.2	2,340,921.2	4,776,677.9	896.1
3	Хан-Уул	3,645,194.3	1,799,633.5	1,845,023.4	537.4
4	Чингэлтэй	2,556,911.5	688,024.6	1,868,886.9	-
5	Сүхбаатар	1,554,080.5	92,558.2	1,461,471.9	50.4
6	Сонгинохайрхан	5,313,414.1	879,225.1	4,372,072.5	62,116.5
7	Багануур	2,443,869.0	251,532.1	2,099,937.9	92,399.0
8	Багахангай	404,683.6	21,850.1	376,917.7	5,915.8
9	Налайх	1,692,386.0	87,378.6	1,562,180.1	42,827.3
10	Нийслэл ОНХС	34,390,252.8	14,023,834.3	20,366,418.5	-
	Нийт	61,408,842.8	20,488,438.4	40,715,661.9	204,742.5

ОНХС-ийн эх үүсвэрийн 34%-ийг өмнөх оны үлдэгдэл санхүүжилт, 66%-ийг ОНХНС-ийн орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн байна.

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.8¹-д заасны дагуу тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар батлуулжээ.

Нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор өмнөх оны үлдэгдлийг 17,265.7 сая төгрөг гэж баталсан боловч ОНХС-ийн дансны үлдэгдлийг тулгахад 20,448.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 3,222.7 сая төгрөгийн зөрүүтэй байна.

Хүснэгт №2. Өмнөх оны үлдэгдэл зөрүү

/сая.төг/

№	Нэр	ИТХ-ын тогтоолоор	Дансны үлдэгдэлээр	Зөрүү үнийн дүн
1	Нийслэл	13,313.7	14,023.8	(710.1)
2	БГД	-	303.5	(303.5)
3	БЗД	2,340.9	2,340.9	-

¹ 8.8.ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ.

4	БНД	251.5	251.5	-
5	БХД	21.9	21.9	-
6	НД	87.4	87.4	-
7	СБД	88.9	92.6	(3.7)
8	СХД	634.7	879.2	(244.5)
9	ХУД	-	1,799.6	(1,799.6)
10	ЧД	526.7	688.3	(161.6)
	<i>Нийт</i>	17,265.7	20,488.4	(3,222.7)

Бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байдлыг харвал ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас орох төлбөрийг улсын төсөвт шууд татан төвлөрүүлдэг учир нийслэл, дүүрэгт тооцоолол хийгддэггүй, СЯ-ны бүрдүүлэлтээр шилждэг байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэрээр бүрдүүлжээ.

1.1.2. ОНХНС-аас нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж олгосон уу?

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС-аас НОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 41,325.1 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2², МУ-ын ЗГ-ын 2017 оны "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын дагуу СЯ-аас Нийслэлийн ОНХС-д тухайн онд олгох орлогын шилжүүлгийг сар бүрийн төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3. ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг

№	Үзүүлэлт, сар	Төлөвлөгөө	Сангийн яамны шилжүүлэг /сая.төг/
1	1 сар	0	0
2	2 сар	2,434.7	2,434.7
3	3 сар	3,246.2	3,177.2
4	4 сар	3,258.7	3,344.8
5	5 сар	3,246.2	3,042.6
6	6 сар	3,246.2	3,042.6
7	7 сар	4,323.9	3,608.3
8	8 сар	4,311.3	5,290.5
9	9 сар	4,311.3	4,285.2
10	10 сар	4,317.6	4,158.0
11	11 сар	4,311.3	4,335.4
12	12 сар	4,317.6	4,268.0
	Нийт	41,325.1	40,987.3

Дүгнэлт: ОНХНС-аас Нийслэлийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийг сар бүрийн төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.

1.1.3. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон уу?

НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хуваарийг НЗД-ын 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/47 дугаар захирамжаар 45,813.4 сая төгрөгөөр баталсан.

Тус хуваарьт СС-ын 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 134 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулснаар НЗД-ын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн

² 59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

А/971, 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/1373 дугаар захирамжаар өөрчлөлт оруулжээ.

НОНХС-аас ДОНХС-д 20,662.5 сая төгрөг шилжүүлэхээр төлөвлөсөн боловч 20,349.3 сая төгрөгийг шилжүүлж, 313.3 сая төгрөгийг дутуу буюу төлөвлөгөөний дагуу шилжүүлээгүй байна.

Хүснэгт № 4. 2021 оны ДОНХС-д олгосон санхүүжилт

№	Дүүргийн нэр	Төлөвлөгөө	Олгосон санхүүжилт	/сая.төг/	
				Дутуу шилжүүлсэн дүн	
1	БГД	2,016.7	1,986.1	30.6	
2	БЗД	4,850.2	4,776.7	73.5	
3	БНД	2,132.3	2,099.9	32.4	
4	БХД	382.7	376.9	5.8	
5	НД	1,586.2	1,562.2	24.0	
6	СБД	1,484.0	1,461.5	22.5	
7	СХД	4,439.4	4,372.1	67.3	
8	ХУД	1,873.4	1,845.0	28.4	
9	ЧД	1,897.7	1,868.9	28.8	
Дүн		20,662.5	20,349.3	313.3	

НОНХС-аас ДОНХС-д олгох санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгох шаардлагатай байна.

Дүгнэлт: НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлгийг СЯ-аас орлогыг хуганцаанд нь шилжүүлээгүйгээс батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.4. Нийслэл, дүүргийн ОНХС-д хуульд заасан эх үүсвэрийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөсөн үү?

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр хуульчилсан. Эдгээр эх үүсвэрээс малын тоо толгойн албан татварын орлогыг БНД, БХД, СХД, НД бүрдүүлэхээр нийт 269.7 сая төгрөг төлөвлөж, бусад дүүрэг нь төлөвлөдөггүй байна. Гүйцэтгэлээр БНД 92.4 сая, БХД 5.9 сая, СХД 46.8 сая, НД 42.8 сая, нийт 187.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь дүүргүүдэд малын тоо, толгойн албан татварын орлогыг бүрдүүлэх боломжийг бүрэн судлаагүй байна.

Нийслэл, дүүргийн ОНХС-д төвлөрүүлэх орлогыг хуульд заасан эх үүсвэрээр бүрдүүлж байгаа боловч эх үүсвэр тус бүрээр бүрдүүлэх ажил хангалтгүй, нэмэлт эх үүсвэрээр төлөвлөх тооцоо судалгааг нийслэл, дүүргээс хийгээгүй байна.

Цаашид хуульд заасан эх үүсвэр тус бүрээр ОНХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх боломжийг судалж орлогыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглаж, төлөвлөж чадаагүй байна.

1.2. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн үү?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө иргэдийн саналыг авч орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөжээ.

1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хавсралтын 5.2.1, 5.2.2, 5.2.3-т заасны дагуу иргэдээс санал авч зохион байгуулахаар тусгажээ. Нийслэл,

дүүргийн ЗДТГ нь 2023 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг “/onhs.mof.gov.mn/” цахим программ ашиглан 18-аас дээш насны 735,508 иргэдээс авсан байна.

Хүснэгт №5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд өгсөн иргэдийн оролцоо, санал

№	Аймаг, нийслэл	Дүүргийн нэр	Саналын тоо /хэлбэр/			Нийт санал өгсөн иргэдийн тоо	Нийт санал /ажлаар/		Батлагдсан санал		Цуцлагдсан санал	
			Цахим	Бүлгийн ярилцлага	цаасаар		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
0	1	2	3	4	5	6=3+4+5	7	8	9	10	11	12
1	Нийслэл	Баянгол	4300	3400	10987	18687	393		34	2,267.3	359	
2	Нийслэл	Баянзүрх	18854	539	314040	333433	424		26	4,850.2	398	
3	Нийслэл	Багахангай	599		501	1100	8		3	378,740.9	5.0	
4	Нийслэл	Багануур	26230		13992	40222	16		9	2,167,520.6	7	
5	Нийслэл	Налайх	4912	270	6698	11880	15		6	1,257,978.1	9	
6	Нийслэл	Сүхбаатар	11834		31046	42880	430		11	1,166,819.4	419	
7	Нийслэл	Сонгинохайрхан	14122		50000	64122	18		3	4,451,900.0	15	
8	Нийслэл	Хан-Уул	19298		82370	101668	31		4	1,962,922.2	27	
9	Нийслэл	Чингэлтэй	4142		117374	121516	32		24	1,492,027.1	8	
10	Нийслэлийн нийт дүн		104291		627,008	735,508	1,367		120	12,885,026	1,247	

Дээрх хүснэгтээс харахад хүн амын тоо, нутаг дэвсгэрийн онцлог бүхий томоохон дүүрэг болох БГД, СХД-т санал өгөх иргэдийн оролцоо бусад дүүргүүдтэй харилцан адилгүй байгаа нь ОНХС-ийн талаарх танилцуулга, мэдээлэл хүртээмжтэй хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байна.

НОНХС, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр нийт 735,508 санал өгч үүнээс цахим санал буюу давхардсан тоогоор 104,291 цахим санал, 4,209 бүлгийн ярилцлага, 627,008 цаасан санал ирүүлснээс холбогдох хууль, журмын дагуу эрэмбэлэгдсэн 1367 ажлаас 12,885.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 120 ТАХ батлагдан 1247 ТАХ цуцлагдсан байна. Дүүрэг тус бүрээр авч үзвэл:

БГД

“Ногоон байгууламж нэмэгдүүлэх” ТАХ иргэдээс хамгийн олон санал авч 1 дүгээрт эрэмбэлэгдсэн хэдий ч уг ажил бага хийгдсэн ба эрэмбэлэх үеийн үр ашгийн тооцоолол хийгээгүй. ИНХ-ын тогтоолоор баталгаажаагүй байна.

СБД

СБД-ийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулсан ч ИНХ хуралдаж тогтоол гараагүйгээс шалтгаалан иргэдийн саналыг эрэмблээгүй урьдчилсан жагсаалт гаргасан байна. Эрэмбэлэх үеийн үр ашгийн тооцоолол хийгээгүй байна.

БЗД

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 5 дугаар зүйлийн 5.13 дугаар заалтад хөрөнгө оруулалт, хөтөлбөр ТАХ-ний саналын жагсаалтыг ИНХ хурлын тогтоолоор батлана гэж заасан боловч ИНХ хуралдаагүй байна. Ажлын хэсэг байгуулан журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан боловч бүрэн хэрэгжээгүй иргэдийн саналыг авч эрэмблэхдээ ИНХ-ын тогтоолгүйгээр эрэмбэлэн үр ашгийн тооцоолол хийгээгүй байна.

ЧД, ХУД

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу ажлын хэсэг байгуулан ИНХ-аас ирүүлсэн тогтоолоор иргэдээс санал авч эрэмбэлсэн ч эрэмблэхдээ үр ашгийн тооцоолол хийдэггүй байна.

СХД

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 6 дугаар зүйлийн 6.1-ийн дагуу ажлын хэсэг байгуулаагүй бөгөөд ИНХ-аас тогтоол гараагүй, эрэмблэхдээ үр ашгийн тооцоолол хийгээгүй байна.

Нийслэл

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн дагуу НЗД тамгын газар ажлын хэсэг байгуулаагүй, саналыг эрэмблээгүй үр ашгийн тооцоолол хийгээгүй СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө нийслэл, дүүрэг нь иргэд олон нийтээс санал авч байгаа боловч орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г ОНХС-ийн журмын 4.1.1³, 4.3.1⁴, 6.10⁵-т заасны дагуу хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөхөөр заажээ.

2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх ТАХ-г “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”, “ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөжээ.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулжээ.

1.2.2. Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангасан төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

2023 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 18,460.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 77 багц ТАХ, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 17,247.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 119 багц нийт 35,708.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 196 ТАХ шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Анх төлөвлөгдөж батлагдсан ТАХ-нд 1-2 удаа төсвийн тодотгол хийгдэж ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 23,769.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 79 багц ТАХ, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 21,279.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 164 багц нийт 45,048.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 243 ТАХ болж нэмэгдсэн байна.

Хүснэгт №6. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт

³ 4.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

⁴ 4.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

⁵ 6.10. Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр иргэд, малчдаас гаргасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг журмын 4.5-д заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн бэлчээр ашиглалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан боловсруулж ИТХ-д танилцуулж батлуулна.

№	Тогтоолын утга	НИТХ-ын 2023 оны төсөв батлах тухай тогтоол				Тогтоолын зөрүү		НИТХ -ын сүүлийн тодотгол		ДИТХ-ын 2023 оны төсөв батлах тухай тогтоол				Тогтоолын зөрүү		ДИТХ-ын сүүлийн тодотгол	
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	БГД	5	1,800.0	-	-	5	1,800.0	12	1,532.7	23	734.60	35	2,267.3				
2	БЗД	13	3,000.0	4	1,000.0	17	4,000.0	21	3,813.5	5	1,036.70	26	4,850.2				
3	БНД	2	600.0	-	-	2	600.0	5	1,678.4	4	489.10	9	2,167.5				
4	БХД	5	300.0	-	-	5	300.0	2	306.0	1	91.70	3	397.7				
5	НД	3	600.0	1	-	4	600.0	29	1,650.6	-8	-338.10	21	1,312.5				
6	СБД	4	1,200.0	-	-	4	1,200.0	11	1,384.9	3	317.10	14	1,702.0				
7	СХД	25	3,000.0	-1	-	24	3,000.0	9	3,490.7	1	1,047.30	10	4,538.0				
8	ХУД	7	1,800.0	-	-	7	1,800.0	2	1,473.6	2	489.30	4	1,962.9				
9	ЧД	4	1,200.0	-3	-	1	1,200.0	28	1,917.5	4	0.00	32	1,917.5				
10	Он дамжин	8	3,787.7	1	1,996.5	9	5,784.2	-	-	-	-	-	-				
11	Бусад	1	1,172.8	-	1,812.8	1	2,985.6	-	-	-	-	-	-				
Нийт дүн		77	18,460.5	2	-	79	23,769.7	119	17,247.9	35	3,867.7	164	21,279.0				

Нийслэл, дүүргийн ОНХС-аас шинээр хэрэгжүүлэхээр баталсан 233 ТАХ-нээс 32 ТАХ нь батлагдсан зураг төсөвгүй, нэр байршил нь тодорхой бус ТАХ-г тусган баталжээ.

НОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 77 багц ТАХ-ний нэр, байршил, төсөвт өртгийг өөрчилж 151 ТАХ болгож НЗД-ын захирамжаар задалсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4-т “санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран төсөл арга хэмжээ нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасныг зөрчжээ. Тухайлбал:

НОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 6,140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэр, байршил нь ерөнхий байдалтай 19 ТАХ-г төлөвлөсөн байна.

Хүснэгт №7. НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дүүрэг	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг /сая.төг/
А	1	2	5	6	7
1	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил-1 (БГД)	БГД	2023	2023	300.0
2	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил-2 (БГД)	БГД	2023	2023	300.0
3	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил(БЗД)	БЗД	2023	2023	513.0
4	Тохижилт, ногоон байгууламжийн ажил (БЗД)	БЗД	2023	2023	300.0
5	Авто зам засвар, тохижилтын ажил-2 (БЗД)	БЗД	2023	2023	300.0
6	Гэрэлтүүлгийн ажил (БЗД)	БЗД	2023	2023	487.0
7	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)	СХД	2023	2023	220.0
8	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, засвар шинэчлэлтийн ажил (СХД)	СХД	2023	2023	300.0
9	Сагсан бөмбөгийн талбайн ажил (СХД)	СХД	2023	2023	50.0
10	Тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (СХД)	СХД	2023	2023	300.0
11	Авто зам засвар, зогсоол (СХД)	СХД	2023	2023	300.0
12	Гэрэлтүүлэг (СХД)	СХД	2023	2023	70.0
13	Тохижилт, засвар шинэчлэлт, тоног төхөөрөмж (СХД)	СХД	2023	2023	150.0
14	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил (СХД)	СХД	2023	2023	150.0
15	Хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил (СБД)	СБД	2023	2023	300.0
16	Явган зам, тохижилтын ажил (ХУД)	ХУД	2023	2023	300.0
17	Тохижилтын ажил (ХУД)	ХУД	2023	2023	300.0
18	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (ХУД)	ХУД	2023	2023	300.0
19	Ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн өрөөг засварлах, шинэчлэх ажил (ЧД)	ЧД	2023	2023	1,200.0
Нийт					6,140.0

ДОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 3,268.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэр, байршил нь ерөнхий байдалтай 13 ТАХ-г төлөвлөсөн байна.

Хүснэгт №8. ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дүүрэг	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг /мян.төг/
А	1	2	5	6	7

1	Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад засварлах ажил (Баянгол ДҮҮРЭГ)	БГД	2023	2023	150,000.00
2	Нийтийн ЭЗЭМШЛИЙН гудамж зам талбайн сандал, хогийн сав шинээр суурилуулах ажил (Баянгол ДҮҮРЭГ)	БГД	2023	2023	70,000.00
3	Хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах тусгаарлах хашаа хайс шинээр суурилуулах ажил (Баянгол дүүрэг)	БГД	2023	2023	80,000.00
4	Тохижилтын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	БЗД	2023	2023	365,000.0
5	Засварын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	БЗД	2023	2023	137,000.0
6	Гэрэлтүүлгийн ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	БЗД	2023	2023	385,460.7
7	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зураг төсвийн ажил	БЗД	2021	2023	178,500.0
8	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлуудын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил	БЗД	2021	2023	123,807.6
9	Явган хүний зам сэргээн засварлах	БНД	2023	2023	20,000.0
10	Автобусны буудал байгуулах	НД	2023	2023	274,611.6
11	Дүүргийн нутаг дэвсгэрт тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх	СБД	2023	2023	228,753.8
12	Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг	ХУД	2023	2023	1,000,000.0
13	Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар тохижилтын ажил	ХУД	2023	2023	255,351.1
	Нийт				3,268,484.8

Мөн НОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжих 9,408.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дээрх 32 ТАХ нь зураг төсөвгүй батлагдсан байна. Тухайлбал:

- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил-1 (БГД)” 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил (БЗД)” 513.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД)” 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил (СБД)” 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (ХУД)” 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн өрөөг засварлах, шинэчлэх ажил (ЧД)” 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ байна.

Нийслэл, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-г батлахдаа нэр, төсөвт өртөг тодорхойгүй, ерөнхий нэрээр зураг төсөвгүй баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4⁶, 29.4⁷, СС-ын 2021 оны 86 дугаар журмын 3.1.3⁸ -д заалтыг зөрчсөн нь ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах эрсдлийг бий болгож байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх ТАХ-а батлагдсан зураг төсөвгүй, нэр байршил тодорхой бус байдлаар батлаж, хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна.

1.2.3. Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг тусгасан уу?

НОНХС-аас шинээр хэрэгжүүлэх 23,769.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 79 ТАХ, ДОНХС-аас шинээр хэрэгжүүлэхээр баталсан 21,269.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 164 ТАХ, нийт 44,769.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 243 ТАХ-ээс 44,427.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 238 ТАХ буюу 98% нь тухайн шатны чиг үүрэгт хамаарах ТАХ-г тусган баталжээ.

Харин НОНХС-аас хэрэгжүүлэх 270.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ, ДОНХС-аас 342.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ нь тухайн шатны чиг үүрэгт хамаарахгүй ТАХ байна. Тухайлбал: Зураг төсөл боловсруулах ТАХ-ний зардал. Хавсралт №1

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-аас шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ нь тухайн шатны чиг үүрэгт хамаарах ТАХ байна.

⁶ 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

⁷ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁸ 3.1.3.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ

2.1. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан уу?

НЗД-ын 77 удаагийн захирамжаар НОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 23,225.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 151 ТАХ-ний ХАА зохион байгуулах эрхийг харьяа 17 газарт шилжүүлжээ. /Тайлбар:НЗД-аас 79 ТАХ-г хэрэгжүүлэх захирамж гаргахдаа нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 151 ТАХ болгон хуваасан./

Дүүргийн ОНХС-ийн 21,269.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 164 ТАХ-ний ХАА-г буюу тухайн дүүргийн ХАА-ны албанд зохион байгуулжээ.

Нийт нийслэлийн хэмжээнд 44,495.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 315 ТАХ-ний ХАА-г зохион байгуулжээ. Үүнээс 2023 онд 36,827.1 сая төгрөгийн төсөвтэй 243 ТАХ буюу 77.1%-ийн ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

Нийслэл ОНХНС, дүүргийн ОНХС-аас тухайн жилд олгосон 61,204.1 сая төгрөгийн эх үүсвэрээс 53,104.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 393 ТАХ-нд санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 38,784.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 355 ТАХ буюу 2023 онд санхүүжих дүнгийн 73%-д санхүүжилтийг олгожээ.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

2023 онд НОНХС-ийн хөрөнгөөр 23,225.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 151 ТАХ, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 21,289.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 164 ТАХ нийт 44,495.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 315 ТАХ-ний ХАА-г нийслэлийн харьяа агентлаг болон дүүргийн ХААА зохион байгуулжээ.


Хүснэгт №9 Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ

/сая.төг/

№	Байгууллагын нэр	Эрх шилжүүлсэн		Гэрээ байгуулагдсан ТАХ		Гэрээний дүн
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	
1	БГД	39	3,767.3	31	2,997.3	2343.7
2	БЗД	32	5,775.9	25	4,456.8	852.5
3	БНД	17	2,936.7	13	2,863.7	2763.8
4	БХД	11	768.7	11	768.7	366.7
5	ЗАА	3	600.0	3	600.0	592.1
6	НБГ	14	954.8	12	894.8	795.0
7	НД	40	2,250.6	40	2,250.6	2201.9
8	НХААГ	40	4,245.3	20	2,682.8	2584.2
9	НХОГ	12	7,531.7	10	7,476.7	7350.5
10	НЦХМТГ	4	278.5	2	58.5	48.3
11	НЭМГ	5	50.0	5	50.0	49.3
12	СБД	13	1,758.0	10	1,395.8	1359.3
13	СХД	33	6,551.9	23	5,089.9	3639.0
14	УБЗАА	8	886.0	2	150.0	149.9
15	ХТГ ОНӨААТҮГ	4	1,600.0	4	1,600.0	1600.0
16	ХУД	8	2,622.9	6	2,099.4	1652.8
17	ЧД	32	1,917.5	26	1,392.2	1284.2
Нийт		315	44,495.9	243	36,827.1	29,633.2

Нийт ТАХ-ээс 40,126.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 277 ТАХ буюу 90.2%-г ТБОНӨХБАҮХАТХ-ийн 53 дугаар зүйлийн 53.2⁹-т заасны дагуу мэргэжлийн байгууллага болох НХААГ болон дүүргүүдийн ХААА-нд эрхийг шилжүүлжээ.

Дүрслэл № 1. ХАА зохион байгуулах эрхийг шилжүүлсэн байгууллагаар нь харуулбал



ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд эрх шилжүүлсэн 315 ТАХ-ээс 77.1% буюу 36,281.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 243 ТАХ-ний ХАА-г тухайн онд багтаан зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулжээ. Тендер шалгаруулалтын дараах аргийг хэрэглэжээ. Үүнд:

- 102 ТАХ буюу 76.3%-г нээлттэй тендер шалгаруулалтын арга;
- 61 ТАХ буюу 10.0%-г харьцуулалтын арга;
- 69 ТАХ буюу 7.8%-г гэрээ шууд байгуулах;
- 11 ТАХ буюу 5.9%-г бусад аргаар зохион байгуулжээ.

Харин тухайн онд багтаж гэрээ хийгдээгүй 22.8% буюу 7,668.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 ТАХ-ний ХАА үргэлжилж байна.

ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан 21,194.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 128 ТАХ буюу 53%-ийг аудитын түүвэрт хамруулан шалгахад 30 ТАХ-д дараах зөрчлүүд илэрсэн. *Хавсралт 3. Тухайлбал:*

- *Ерөнхий нөхцөлийг магадлах шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй-16;*
- *Санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй-1;*
- *Тендерийн баримт бичигт боловсруулахтай холбоотой-3;*
- *Техникийн чадавх болон туршлагыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй-5;*
- *Тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл шаардлага-5.*

ХАА-г ил тод нээлттэй, өрсөлдөх тэгш боломжийг ханган зохион байгуулсан ч зарим ТАХ-ний сонгон шалгаруулалтад ТББ болон тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэх, ТАХ-г хэрэгжүүлэх явц, үр дүнд тавих хяналт, шат шатны хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.


⁹ 53.2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан уу?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл 20,488.4 сая төгрөг, ОНХС-аас тухайн жилд олгосон санхүүжилтийн 40,715.7 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 204.7 сая төгрөг нийт 61,408.8 сая төгрөгийн эх үүсвэрээс 53,104.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 393 ТАХ-нд санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 38,784.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 73% буюу 355 ТАХ-нд санхүүжилтийг олгожээ.

Дүрслэл №2. Нийслэл, дүүргийн 2023 онд олгосон нийт санхүүжилт

/сая.төг/



ТАХ-нд гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон боловч цаашид анхаарах дараах асуудлууд байна. Тухайлбал:

- 2023 онд санхүүжих дүнгийн ХУД 24.3%, ЧД 66.8%, БЗД 64.7%-ийг олгосон нь ТАХ-ний хэрэгжилт удаашралтай, ТАХ-г анх зураг төсөвгүй болон ерөнхий нэр, байршилтайгаар төлөвлөн төсвийн тодотголын явцад дахин өөрчлөн ИТХ батлах, 3Д захирамжлах зэргээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зориулалт бус шинжтэй ТАХ-г төлөвлөж, баталж байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн, үр нөлөөтэй байна уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч төлөвлөсөн зорилтод хүрэх түвшин, гарах үр нөлөө тодорхойлоогүй байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр ашиг, үр дүнд хүрсэн үү?

ОНХС-аар хэрэгжүүлэхээр ИТХ-аар батлагдсан 392 ТАХ нь төсвийн тодотгол, 3Д-ын захирамжаар өөрчлөгдөн 513 ТАХ болж задарсан байна.

Хүснэгт №10. ТАХ-ний хэрэгжилтийн байдал

Д/д	Нийслэл, дүүргийн нэр	ИТХ-ын тогтоолоор батлагдсан ТАХ-ний тоо	3Д-ын захирамжаар батлагдсан ТАХ-ний тоо	Гэрээ байгуулсан ТАХ-ээс		Огт хэрэгжээгүй
				Бүрэн хэрэгжсэн	Дутуу хэрэгжсэн	

1	Баянгол	36	36	26	1	9
2	Баянзүрх	52	52	25	27	0
3	Багануур	16	15	10	3	2
4	Багахангай	4	4	2	1	1
5	Налайх	32	32	30	2	0
6	Сонгинохайрхан	22	26	21	3	2
7	Сүхбаатар	16	16	12	1	3
8	Хан-Уул	10	11	3	7	1
9	Чингэлтэй	43	43	30	13	0
10	Нийслэл ОНХС	161	278	120	71	87
	Нийт дүн	392	513	279	129	105

Тухайн ондоо хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний НД 84.4%, СХД 81.5%, БХД болон СБД 75%, БГД 72.2%, ЧД 69.8%, БНД 62.5%-ийг бүрэн хэрэгжүүлсэн бол Нийслэл 46%, БЗД 48.1%, ХУД 27.3%-тай буюу хэрэгжилт хангалтгүй байна.

ОНХС-ийн дутуу хэрэгжсэн ажлуудын шалтгаан нөхцөлийг тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалан гэрээний үнийн дүн нэмэгдсэнээс тухайн ТАХ-ний гүйцэтгэгч ажлыг дуусгаж чадахгүйд хүрч гэрээг цуцлах хүртэл хэмжээнд хүрсэн;
- Газар чөлөөлөлтэй холбоотойгоор ажил хойшилсон зэрэг шалтгаантай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт болон хэрэгжилтийн байдалд нийслэл, дүүргийн хэмжээнд үр дүнг бодитой тодорхойлж тайлагнаагүй байна. Мөн аудитын явцад ТАХ-ний хэрэгжилтийг үзэхэд 55.5%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь ТАХ төлөвлөсөн зорилтот түвшинд бүрэн хүрээгүй буюу үр ашиг, үр дүн хангалтгүй байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй байна уу ?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн ТАХ-г хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангасан бодит үр дүнд хүрсэн байна.

ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг газар дээр нь тулган баталгаажуулахад дараах ТАХ-нүүд үр дүн багатай байна. Үүнд:

НОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд:

- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД, 35 дугаар хороо)” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн 3х3 сагсан бөмбөгийн талбай СХД дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэж буй авто зам, гүүрэн байгууламжын зурваст өртөж сагсан бөмбөгийн талбайг буулгасан;
- “Тохижилтын ажил (ХУД)” 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн ХУД-ийн 6, 7 дугаар хороонд автобус буудлын ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийн ажил хийгдээгүй, автобусны чиглэлийн мэдээллийг байршуулаагүй;
- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (БГД, 5 дугаар хороо)” 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн авто зогсоолын талбайн цемент үйрч сул шороо үүссэн;
- “Хүүхдийн тоглоомын талбай (БГД, 7 дугаар хороо)” 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн ком тоглоомын суурийн бэхэлгээний боолт алга болж тоглоомонд сул хөдөлгөөн үүссэн;

- “Ухаалаг усан сан (СХД, 31 дүгээр хороо)” 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн 628 дугаар худагны карт унших төхөөрөмж ажиллагаагүй;
- “Сагсны болон хөл бөмбөгийн талбай тохижуулах ажил (СХД, 7, 14 дүгээр хороо)” нийт 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд СХД-ийн 7 дугаар хороонд хийгдсэн сагсан бөмбөгийн талбайн сагсны самбар төмөр хийцлэлтэй, гагнасан холболттой стандарт бус бөгөөд цахилгааны өндөр хүчдэлийн шугамны доор байршиж байгаа зэрэг нь үр ашиг, үр дүнгүй хөрөнгө оруулалт хийснийг харуулж байна.

ДОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд:

- “Баянгол дүүрэг 31 дүгээр хороо, 96-р байрны ар талын талбайн тохижилт” 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн тоглоомын талбай, тохижилтын ажлын налуу цементбетон пандус стандарт бус налуутай, аюулгүй байдлыг бүрэн хангаагүй;
- Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (СХД, 33 дугаар хороо)” 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд авто зогсоолын талбайг эко хавтангаар хийсэн /зориулалтын бус материал ашигласан/;
- “Авто зогсоол хийх (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо)” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд авто зогсоолын талбайг эко хавтангаар хийсэн /зориулалтын бус материал ашигласан/;
- “Гудамж сайжруулах (ЧД, 19 дүгээр хороо)” 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн авто зогсоолын талбайн цемент үйрч сул шороо үүссэн;
- “Баянзүрх дүүргийн 2, 11, 20, 21 дүгээр хороодод тус бүр 1 зөөврийн худаг байгуулах тохижилтын ажил” 387.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд хийгдсэн худгын усны машин гарч зогсох зогсоол нарийн эргэлтийн талбай хязгаарлагдмал;
- “Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо 11, 12 дугаар байрны гадна талбайн тохижилтын ажил” 371.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд авто зогсоолын талбайг эко хавтангаар хийсэн /зориулалтын бус материал ашигласан/;
- “Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо 204, 205 дугаар байрны дунд тохижилтын ажил” 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний хүрээнд авто зогсоолын талбайг эко хавтангаар хийсэн /зориулалтын бус материал ашигласан/ зэрэг нь үр ашиг, үр дүнгүй хөрөнгө оруулалтыг хийснийг харуулж байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байгаа ч зарим ТАХ-ний хэрэгжилт, үр дүнд анхаарах шаардлагатай байна.

2.3.ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна уу?

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс зарим хөрөнгө эвдэрч гэмтсэн байна.

2.3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-нд ашиглагч байгууллагаас тавих хяналт, хамгаалалт хангалтгүйгээс зарим ажлын тоног төхөөрөмж эвдэрч гэмтсэн байна. Тухайлбал:

- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /СХД 35 дугаар хороо/” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Сагсны талбай хийгдсэн ч, замын трасстай давхацсан тул нураасан, зориулалтын дагуу ашиглаагүй;
- “Тоглоомын талбайн засвар, шинэчлэлтийн ажил /ЧД 1, 5, 8 дугаар хороо/” 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. 5 дугаар хороонд хийгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн савлуур эвдэрсэн, зориулалтаар ашиглах боломжгүй болсон;

Зураг №1 “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /СХД 35 дугаар хороо/” ТАХ



Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ний ажлын хяналт, хамгаалалт дутуугаас зарим ажлын хэрэгжилт хангалтгүй, зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.

2.3.2. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна уу?

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасан байдаг.

ОНХС-ийн хөрөнгийн үр дүнд бий болсон хөрөнгийг өмчид бүртгэх байгууллага тодорхойгүйгээс хадгалалт, хамгаалалт эзэнгүйдэж эд хөрөнгө эвдрэх, гэмтэх нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал:

- “Хүүхдийн тоглоомын талбай /БГД, 7-р хороо/” 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Суурилуулсан савлуур ага болсон;
- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил /ХУД 9, 10, 16, 21 дүгээр хороо/” 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Тарьсан зарим моднууд гэмтэж, үхсэн;
- “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /СХД 32 дугаар хороо/” 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Суурилуулсан гулсуур хугарч, гэмтсэн;
- “Хүүхдийн тоглоомын талбай засварлах, шинэчлэх /ЧД 2 дугаар хороо/” 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Сагсны шит хагарсан, ашиглах боломжгүй байна;
- “Сагсан бөмбөгийн талбай байгуулах /СХД 32 дугаар хороо/” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Бүтээн байгуулалтаар хийгдсэн 4 ширхэг гэрлээс 1 гэрэл алга болсон;
- “156 дугаар цэцэрлэгийн камержуулалтын ажил /СХД 27 дугаар хороо/” 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Камерны төхөөрөмжийг галын хайрцагт байршуулсан байна.

Зураг №2 “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /СХД 32 дугаар хороо/”



Зураг №3 “156 дугаар цэцэрлэгийн камержуулалтын ажил /СХД 27 дугаар хороо/”



Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНАСАН ЭСЭХ

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад шат шатны ИТХ, дотоод аудитын албадууд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад нийслэл болон 9 дүүргийн ИТХ нь хяналт хэрэгжүүлээгүй, нийслэл болон 4 дүүргийн дотоод аудитаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дотоод аудит нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан уу?

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 9.4¹⁰-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд нийслэл болон 9 дүүргийн ИТХ-аас журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дүүргүүдийн дотоод аудитын нэгжээс дараах байдлаар хяналт хэрэгжүүлэн ажиллажээ:

- БГД-ийн ЗД-ын дэргэдэх дотоод аудитын албанаас дүүргийн болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-үүдийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд аудит хийжээ.
- ЧД-ийн ЗД-ын удирдамжийн дагуу дотоод аудитын албанаас хяналтыг хэрэгжүүлэн 2023 оны 11 сарын 2-ны өдөр ЧД-ийн ЗДТГ-т 13 зөвлөмж өгсөн байна.
- БНД-ийн ЗД-ын дэргэдэх дотоод аудитын албанаас хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлд нийцлийн аудит хийж дүүргийн ЗДТГ-т 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.
- НД-ийн ЗД-ын дэргэдэх дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд аудит хийж “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг дүүргийн ЗДТГ-т хүргүүлжээ.
- БХД-ийн ЗД-ийн дэргэдэх дотоод аудитын албанаас 2023 оны ОНХС-ийн гүйцэтгэлд нийцлийн аудит хийж 1 зөвлөмжийг дүүргийн ЗДТГ-т хүргүүлэн ажиллажээ.

Харин нийслэл болон СБД, БЗД, ХУД, СХД-үүдийн ЗД-ийн дэргэдэх дотоод аудитын албадууд журамд заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй бөгөөд үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлээгүй нь СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 9.8¹¹ заалтыг зөрчжээ.

Нийслэл, дүүргийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд хууль, журмаа бүрэн гүйцэд судлаагүй, эрх зүйн актад заасан чиг үүргийн талаарх ойлголт хангалтгүйгээс хэрэгжилт дутмаг байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ИТХ-аас ОНХС-ийн гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, дотоод аудитын албадуудаас хэрэгжүүлсэн хяналт хангалтгүй байна.

¹⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд ..нийслэл, .. дүүргийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо ...Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, ..нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.”

¹¹ 9.8. Энэ журмын 9.4, 9.5-д заасан байгууллага дангаараа болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ.

3.1.2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн үү?

НОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн ТАХ-нд захиалагчийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлжээ.

Хүснэгт № 11 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл

/сая.төг/

№	Нийслэл, дүүрэг	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		Захиалагчийн хяналт			
				Хэрэгжүүлсэн ТАХ		Хэрэгжүүлээгүй ТАХ	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	Баянгол дүүрэг	27	1,460.3	13	1,186.2	14	274.1
2	Сүхбаатар дүүрэг	12	1,137.3	12	1,137.3	-	-
3	Баянзүрх дүүрэг	52	4,650.2	40	4,650.2	12	-
4	Чингэлтэй дүүрэг	33	1,620.2	12	1,620.2	21	-
5	Хан-Уул дүүрэг	11	891.6	11	891.6	-	-
6	Багануур дүүрэг	16	2,097.6	14	2,072.7	2	24.9
7	Налайх дүүрэг	27	1,566.2	27	1,566.2	-	-
8	Багахангай дүүрэг	4	353.4	2	329.4	2	24.0
9	Сонгинохайрхан дүүрэг	18	3,216.5	18	3,216.5	-	-
	Дүүргийн дүн	200	16,993.3	122	16,670.3	50	323.0
1	Нийслэл ОНХС	165	21,203.5	165	21,203.5	-	-
	Нийт дүн	365	38,196.9	287	37,873.8	50	323.0

НОНХС-аар 2023 онд нийт 365 ТАХ-г 38,196.9 сая төгрөгөөр санхүүжүүлсний 287 ТАХ-нд захиалагчийн хяналтыг 9 дүүрэг, нийслэлийн 8 байгууллага хэрэгжүүлэн ажиллажээ.

Хүснэгт №12 Дүүргийн захиалагчийн хяналтад олгосон зардал

/сая.төг/

№	Дүүрэг	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээ		Захиалагчийн хяналтад олгосон дүн
		тоо	Дүн	
1	Баянгол дүүрэг	27	1,460.3	20.1
2	Сүхбаатар дүүрэг	12	1,137.3	20.7
3	Баянзүрх дүүрэг	52	4,650.2	69.5
4	Чингэлтэй дүүрэг	43	1,620.2	10.8
5	Хан-Уул дүүрэг	11	891.6	8.9
6	Багануур дүүрэг	16	2,097.6	11.1
7	Налайх дүүрэг	27	1,566.2	-
8	Багахангай дүүрэг	4	353.4	-
9	Сонгинохайрхан дүүрэг	18	3,216.5	47.2
	Дүүргийн дүн	210	16,993.3	141.2

9 дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 210 ТАХ-нд 16,993.4 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 141.2 сая төгрөгийг захиалагчийн хяналтын зардалд олгожээ. Аудитаар захиалагчийн хяналттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ:

- ОНХС-ийн хөрөнгөөр ХУД-т хэрэгжсэн 244.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй, нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, шинэчлэлт, тохижилтын ажил /багц-2/-ыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд гүйцэтгэгч байгууллагын төлөөллийг оруулаагүй, зөвхөн захиалагч байгууллагын төлөөллийг оруулсан нь МУЗГ-ын 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хавсралт 1-т заасныг зөрчжээ.

- ЧД-ийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЧДХААА-ДОНХС-А22/21 гэрээний дугаартай, 63.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Гудамж сайжруулах 13 дугаар хороо” ТАХ-ний захиалагчийн хяналтын тайлан байхгүй, архивт ЧДХААА-ДОНХС-А23/15 гэрээний дугаартай ТАХ-ний захиалагчийн хяналтын гэрээний тайланг хавсаргасан бөгөөд захиалагчийн хяналтын зардалд 0.9 сая төгрөгийг олгосон байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим ТАХ-ний захиалагчийн хяналтыг хууль, журамд заасны дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.3. Хөндлөнгийн болон дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд өгсөн шийдвэрийн биелэлтийг хангаж, хяналтыг хэрэгжүүлж ажилласан уу?

ОНХС-ийн хөрөнгө оруулалт, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагнал, бүртгэл нь холбогдох хууль журамтай нийцэж буй эсэхэд НТАГ-аас аудит хийж, 2022 оны 06 сарын 06-ны өдөр НХОГ ОНӨААТҮГ, УБЗАА, БЗД, БНД, НД, ХУД, ЧД-т 522, 523, 524, 525, 526, 527, 528 тоот 7 албан шаардлага, Нийслэл, дүүргийн ИТХ, Нийслэл, дүүргийн Засаг дарга нарт 2022 оны 06 сарын 02-ны өдрийн А/12 тушаалаар батлагдсан тайлангаар 50 зөвлөмжийг хүргүүлжээ.

Нийслэл, дүүргүүдийн ИТХ, ЗДТГ болон холбогдох бусад байгууллагуудаас албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хугацаандаа багтаан 100 хувь бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. **Хавсралт**

Дүгнэлт: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн үү?

ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн тайланг дүүргүүд журамд заасан хугацаанаас хоцроож, бүрэн тайлагнаагүй, зарим ТАХ-г нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна. Мөн хэрэгжүүлж буй ТАХ-ний мэдээллийг УМС, шилэн дансны цахим нэгдсэн хуудаст цаг тухай бүр нь үнэн зөв, бүрэн мэдээллэх шаардлагатай байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнасан уу?

ОНХС-ийн журмын 9.2¹², 9.9¹³-д заасны дагуу тайланг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заажээ.

Дүүргүүд ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг хүргүүлэхдээ журамд заасан зарим мэдээллийг тусгаагүй, хугацаа хоцроосон байна. Тухайлбал: Нийслэлийн 7 дүүрэг нь 2024 оны 2 дугаар сарын 21-нээс 3 дугаар сарын 05-ны хооронд буюу 28-35 хоногийн хугацаа хоцроон албан бичгээр хүргүүлсэн байна.

¹² Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

¹³ 9.9. Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;

9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;

9.9.3.ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;

9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн фото зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;

9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;

9.9.6.ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;

9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга

Дүүргийн бодлого, төлөвлөлтийн хэлтсүүд хэрэгжилтийн тайланг албан бичгээр баталгаажуулж журамд заасан хугацаанд ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн тайланг хүргүүлэхдээ олгосон санхүүжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгээгүй буюу 2024 оны эхний улирлын байдлаар өссөн дүнгээр, журамд заасан зарим мэдээллийг оновчтой бүрэн мэдээлээгүй байна.

Тухайлбал: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний цаашид хэрэгжүүлэх оновчтой санал, аудит болон хяналтын байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмж, албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлагнаагүй байна.

Дүгнэлт: Дүүргүүд ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн тайланг хугацаа хоцроож, журамд заасны дагуу бүрэн тайлагнаагүй, журмын хэрэгжилт хангалтгүй байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж тайлагнасан уу?

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹⁴-д заасны дагуу үнэлж данс бүртгэлд тусгахаар заажээ.

Бүртгэгдвэл зохих 30,886.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 279 хөрөнгөөс 20,343.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 116 хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт №13. ТАХ-г данс
бүртгэлд тусгасан байдал

№	Дүүргийн нэр	Хөрөнгөнд бүртгэх		Бүртгэсэн ТАХ		Бүртгээгүй ТАХ	
		ТАХ-ний		ТАХ-ний		ТАХ-ний	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Нийслэл	103	12,082.9	57	4,963.3	46	7,119.60
2	БГД	20	1,759.7	14	857.7	6	902.0
3	БЗД	48	7,912.8	24	3,984.5	24	3,928.3
4	СХД	18	3,081.1	1	17.2	17	3,063.9
5	СБД	9	1,040.9	9	1,040.9	-	-
6	ХУД	10	4,333.3	1	478.0	9	3,855.3
7	ЧД	38	2,230.9	32	1,691.7	6	539.2
8	НД	38	2,164.2	34	1,739.3	4	424.9
9	БНД	10	1,975.0	7	1,706.9	3	268.1
10	БХД	4	353.4	3	111.1	1	242.3
НИЙТ		279	30,886.4	182	16,590.6	116	20,343.6

Дээрх хүснэгтээс харахад 16,590.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 182 хөрөнгийг бүртгэж тайлагнажээ.

Харин 20,343.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 116 ТАХ-г бүртгээгүй шалтгааныг тодруулахад ажил хийгдэж дуусаагүй, он дамжин хэрэгжиж байгаа, комиссын акт баталгаажаагүй, холбогдох албан тушаалтны хайхрамжгүй үйл ажиллагаа зэрэг шалтгаантай байна.

Эдгээр ажлаас СХД-т хэрэгжиж дууссан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, бүртгэж аваагүй 1,691.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ байна.

Шалтгаан нөхцлийг тодруулахад СХД-ийн Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ нь нийтийн эзэмшлийн хөрөнгийг хариуцан ажиллахаар болсон учир 2023 онд хөрөнгөд бүртгэж аваагүй байна. *Хавсралт 5.*

Тухайлбал:

- 659.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төв замаас Баянхошуу 32-р гудамж 67 тоот хүртэлх авто зам,” /40-р хороо, 0.516 км/
- 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн тоглоомын талбай” /БГД 7-р хороо/
- 280.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “19, 23-р байрны дундах тохижилт”

¹⁴ 9.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.”

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд ашиглалтад хүлээж авсан даруйд нь үнэн зөв бүртгэх, тайлагнах ажиллагаа удаашралтай байна.

3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлсэн үү?

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2.1-д¹⁵ заасны дагуу тухайн шатны ЗДТГ-ын холбогдох албан тушаалтан УМС-д тухайн онд баталсан ТАХ-ний мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор оруулахаар тусгажээ.

УМС-д байршуулсан мэдээллийг шалгахад 2023 онд хэрэгжих 392 багц ТАХ-ээс 46 ТАХ-ний буюу 11.7 хувийн мэдээллийг оруулсан байна.¹⁶

Хүснэгт №14. УМС-д мэдээлэл оруулсан байдал

Нэр	УМС-д оруулах ТАХ-ний тоо			УМС-д оруулсан байгаа тоо
	2023 оны ТАХ	Он дамжсан ТАХ	Нийт	
Баянгол	34	2	36	0
Баянзүрх	26	26	52	26
Багануур	14	2	16	0
Багахангай	3	1	4	16
Налайх	29	3	32	0
Сонгинохайрхан	10	12	22	0
Сүхбаатар	12	4	16	0
Хан-Уул	4	6	10	0
Чингэлтэй	32	11	43	4
Нийслэл ОНХС	79	82	161	0
Нийт	243	149	392	46

/2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар/

Нийслэл, дүүргийн ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудаас мэдээлэл оруулаагүй шалтгаан нөхцөлийг тодруулахад хариуцсан мэргэжилтэн <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/> сайтаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ний саналыг авч нэгтгэж тогтоолд тусгадаг. Харин журмын хэрэгжилтийг хангуулж УМС-д хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээг оруулж олон нийтэд нээлттэй мэдээлээгүй гэсэн тайлбарыг өгсөн.

Харин батлагдсан ТАХ-ний төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг оруулж журмын хэрэгжилтийг хангаагүй. Цаашид тухайн сайтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа тул журамд заасан ажлаа хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Аудитын явцад БГД 26 ТАХ, БНД 16 ТАХ, ХУД 4 ТАХ буюу 2023 онд хэрэгжсэн 30 ТАХ-ний мэдээллүүдийг хугацаа хоцроож нөхөж оруулсан байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулаагүй байна.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цаг тухай бүрт нь мэдээлсэн үү?

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1¹⁷, 6.1.2¹⁸, 6.3.9¹⁹ -т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаарх төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр

¹⁵ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна

¹⁶ <https://onhs.mof.gov.mn/>

¹⁷ 6.1.1. тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

¹⁸ 6.1.2. хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

¹⁹ 6.3.9. орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.

сарын 10-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор мэдээлэхээр заасан.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан эсэхийг шалгахад дараах байдалтай байна.

Хүснэгт №15. Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон болон мэдээлэл дутуу оруулсан дүүргүүд

№	Нийслэл, дүүргийн нэр	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Бүтэн жил	Нийт
	Нийслэл	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	13
1	БГД	-	-	-	1	-	-	1	-	-	-	-	-	-	
2	БЗД	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
3	БНД														
4	БХД	1												1	2
5	НД	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	СБД	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
7	СХД	1											1		2
8	ХУД	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
9	ЧД											1		1	
	Нийт	3	1	1	2	1	1	2	1	1	1	1	2	3	17

Тайлбар: 1-Хугацаа хоцроосон болон дутуу оруулсан

Дүүргүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл оруулж байгаа хэдий ч оруулсан мэдээлэл нь бүрэн бус, хугацаа хоцроож оруулсан байна.

Харин НОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан эсэхийг шалгахад НЗДТГ-аас хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг цаглаварт хугацаанд оруулаагүй хугацаа хоцроож нөхөж оруулсан байна.

Тухайлбал: ЧД, БХД нь ОНХС-ийн жилийн эцсийн тайлан, БНД, БХД-үүд 1-р сарын мэдээллийг хугацаа хоцроож, БГД 4 болон 7 дугаар сарын мэдээллийг дутуу оруулсан.

Иймд ОНХС-ийн мэдээллийг бүрэн гүйцэд, заасан хугацаанд оруулж хэвших шаардлагатай байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллээ бүрэн оруулаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө иргэдийн саналыг авч орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөжээ.
2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 30 ТАХ буюу 13%-д нь шаардлагад нийцээгүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.
3. Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх ТАХ-г батлагдсан зураг төсөвгүй, нэр байршил тодорхой бус байдлаар батлаж, хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна.
4. ОНХС-ийн хөрөнгийн үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс зарим хөрөнгө эвдэрч гэмтсэн байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад нийслэл, дүүргийн ИТХ нь хяналтыг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, зөрчлүүд дахин давтагдаж байна.
6. ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн тайланг журамд заасан хугацаанаас хоцроож, бүрэн тайлагнаагүй, зарим ТАХ-г нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна.
7. Хэрэгжүүлж буй ТАХ-ний мэдээллийг УМС, шилэн дансны цахим нэгдсэн хуудаст цаг тухай бүр нь үнэн зөв, бүрэн мэдээллээгүй.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нийслэл, БГД, БЗД, СБД, СХД, ХУД, ЧД-ийн Засаг дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал авсан, батлагдсан зураг төсөвтэй, орон нутгийн өмчид бүртгэх боломжтой ТАХ-г хэрэгжүүлж ажиллах;
2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлэн, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;

ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХГҮЙ ТАХ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	ТАХ-ний ангилал	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг /сая.төг/
1	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зураг төсвийн ажил	ДОНХС	Зураг төсөв	2021	2023	178.5
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлуудын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил	ДОНХС	Зураг төсөв	2021	2023	123.8
3	ЭМТ-ийн дотор их засварын зураг төсөл, төсөв боловсруулах	ДОНХС	Зураг төсөв	2023	2023	40.0
Нийт дүн						342.3
4	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах (ЧД)	НОНХС	Зураг төсөв	2022	2023	200.0
5	Зураг төслийн ажил /БЗД, 1, 2, 3, 4, 7, 21, 27 дугаар хороо/	НОНХС	Зураг төсөв	2021	2023	70.0
Нийт дүн						270.0

ХАА-НЫ ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

№	Дүүргийн нэр	ТАХ-ний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний дүн	Тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлага хангаагүй
1	БГД	Богд-Ар хорооллын доторх авто замын засвар шинэчлэлт (БГД, 1 дүгээр хороо)	Гоц тех инженеринг ХХК	588,019.93	Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх гэсэн шаардлагад гүйцэтгэгчээр сонгон шалгарсан ХХК-ний санал болгосон нь Нано экологи ХХК-тай байгуулсан ажлын гэрээний туслан гүйцэтгэгчээр ажилласан.
2	БГД	Тоглоомын талбайн засвар, тохижилт (6, 7, 12, 31 дугаар хороо)	Сэтгэшгүй нэмэх ХХК	228,642.87	Ерөнхий инженер, ХАБЭА ажилтан нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна гэсэн шаардлагад Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан Сэтгэшгүй нэмэх ХХК ХХК-ний санал болгосон: Хур системээс татсан мэдээлэлд Ерөнхий инженер Д.Бат-Эрдэнэ нь 2023-02, 2023-03 сард НДШ төлсөн байна.
3	БГД	Нийтийн зориулалттай орон сууцны лифт засвар (5 дугаар хороо)	Шатарын хөвгүүд ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
4	БГД	Нийтийн зориулалттай орон сууцны лифт засвар (5 дугаар хороо)	Шатарын хөвгүүд ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
5	БГД	Баянгол дүүргийн 2 дугаар хороо, Барилгын 7/1, 7/2, 7/3 дугаар байрны бохирын шугам хоолой солих ажил	Бавуу тайж ххк	14,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
6	БГД	Цахилгаан шат засварын ажил (2, 3 дугаар хороо)	Хьёндэ элеватор ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
7	БГД	Цахилгаан шат засварын ажил (5, 6 дугаар хороо)	Минт холи элеватор ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
8	БГД	Цахилгаан шат засварын ажил (7, 26 дугаар хороо)	Цамхаг констракшн ххк, Гэрэлт урсгал Экстрим элеватор ХХК	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.

9	БГД	Цахилгаан шат засварын ажил (12, 34 дугаар хороо)	Бат ирээдүй хүч ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
10	БГД	Цахилгаан шат засварын ажил (13, 15 дугаар хороо)	Шатарын хөвгүүд ххк, Би эл ти бриланат	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
11	БГД	Цахилгаан шат засварын ажил (17,18 дугаар хороо)	Цамхаг констракшн ххк, Хөлөг элеватор, би эл ти брилант ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
12	БГД	Цахилгаан шат засварын ажил (20 дугаар хороо)	Хопи смарт элеватор ххк	10,549.90	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
13	БГД	Цахилгаан шат засварын ажил (25, 28 дугаар хороо)	Оакс урбан элеваторс ХХК	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
14	БГД	Гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажил (2, 16, 20 дугаар хороо)	Алтай байгууламж ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
15	БГД	Гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажил (9, 10, 22 дугаар хороо)	Төгс гэрэлтүүлэг ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
16	БГД	Гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажил (11, 12, 34 дугаар хороо)	Алтай байгууламж ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
17	БГД	Гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажил (13, 14, 15 дугаар хороо)	Төгс гэрэлтүүлэг ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
18	БГД	Гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажил (21, 23 дугаар хороо)	Жи Эл Эм Си ххк	20,000.00	ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий нөхцөл магадлалгүйгээр шууд гэрээ байгуулсан.
19	БЗД	Тожижилт, ногоон байгууламжийн ажил (БЗД)	И Си Си	294,244.15	Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан И Си Си ХХК нь Эй-Ди Интернейшнл ХХК-тай зураг төслийн хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ гэрээг цахим системээр дамжуулан баталгаажуулаагүй байна.
20	БЗД	Хороо-11: Тохижилтын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)	Батлюкс ХХК	224,069.54	ТББ-т "сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онуудыг аль нэг жилд төсөвт өртгийн /төсөвт өртөг 250,001,500/ 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх" шаардлагын дагуу гүйцэтгэгчээр сонгон шалгарсан Батлюкс ХХК-ны борлуулалтын орлого 2 жилийн дундаж нь хүрээгүй.
21	ЧД	Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /10-р хороо/	Мон стийл фиксер ХХК	73,337.41	ТББ-т шаардсан" Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан шалгана" Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан ХХК-ны дээрхи мэдээллийг ХУР системээр шалгаагүй.
22	ЧД	Хорооны нутаг дэвсгэрт камержуулалт хийх /19-р хороо/	Мон стийл фиксер ХХК	73,338.41	ТББ-т шаардсан" Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан шалгана" Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан ХХК-ны дээрхи мэдээллийг ХУР системээр шалгаагүй.
23	НХААГ	Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын	А И Си архитектурс ХХК	124,196.54	ТББ-т шаардсан "барилга байгууламжийн зураг төслийн зөвлөх инженер, барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн инженерийн аль нэг нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна"

		хүчитгэлийн зураг төсөв			шаардлагын дагуу Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан А И Си архитектуртс ХХК-ны дээрхи инженерүүд нь үндсэн ажилтан болох нь нотлогдоогүй.
24	НХААГ	9 дүгээр байрны 4 дүгээр орцны цахилгаан шат (СБД, 7 дугаар хороо)	Фүшили элеватор ХХК	114,937.01	Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан Фүшили элеватор ХХК нь 2023.03.10-ны өдөр туслан гүйцэтгэгч Бета Энержи ХХК-тай байгуулсан гэрээ нь цахим системээр баталгаажуулаагүй байна.
25	НХААГ	8 байрны 5 дугаар орцны цахилгаан шат (СХД, 13 дугаар хороо)	Фүшили элеватор ХХК	124,381.77	Гүйцэтгэгчээр сонгон шалгарсан Фүшили элеватор ХХК нь 2023.03.10-ны өдөр туслан гүйцэтгэгч Бета Энержи ХХК-тай байгуулсан гэрээ нь цахим системээр баталгаажуулаагүй байна.
26	НХААГ	Тохижилт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил (СХД)	Эс Эм Жи Ти ХХК	286,774.79	ТББ-т "Барилгын инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байх шаардлагатай" дагуу гүйцэтгэгчээр сонгон шалгарсан байгууллагын барилгын инженер нь "НД-ийн даатгуулагчийн код 40 -Үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа ажилтан /даатгуулагч/" байна. Мөн гүйцэтгэгчээр сонгон шалгарсан Эс Эм Жи Ти ХХК-ний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтны гэрчилгээний хуулбарыг ирүүлээгүй.
27	ХУД	Тохижилтын ажил (ХУД)	Дагжанпроперти ХХК	280,000.88	ТББ-т шаардсан "ТШЗ 16.2.1 Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ирүүлнэ. Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс өмнө 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу" дагуу гүйцэтгэгчээр сонгон шалгарсан Дагжанпроперти ХХК нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлээгүй.
28	СХД	Төв замаас 151-р сургуулийн авто зогсоол хүртэлх авто зам, 9 дүгээр хороо, 0.258 км	Гоц тех инженеринг ХХК	405,868.81	ТББ-т шаардсан "Үйлчилгээ гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шаардана. Хэрэв шаардах бол тухайн үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхой бичих"- ийг ТШЗ-нд шаардлагатай тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техник хэрэгслийн хүчин чадал заагаагүй.
29	СХД	Зүүн салааны авто замаас 104 дүгээр сургуулийн араар авто машины зогсоол хүртэлх авто зам, 25 дугаар хороо, 0.369 км	Хайрхан уулын зам ХХК	732,530.06	ТББ-т шаардсан "Үйлчилгээ гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шаардана. Хэрэв шаардах бол тухайн үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхой бичих"- ийг ТШЗ-нд шаардлагатай тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техник хэрэгслийн хүчин чадал заагаагүй.
30	СХД	Төв замаас 134 дүгээр сургууль, 215 дугаар цэцэрлэгийн авто машины зогсоол хүртэлх авто зам, 24 дүгээр хороо, 0.318 км	Бумбат даваа ХХК	473,661.12	ТББ-т шаардсан "Үйлчилгээ гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл шаардана. Хэрэв шаардах бол тухайн үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхой бичих"- ийг ТШЗ-нд шаардлагатай тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техник хэрэгслийн хүчин чадал заагаагүй.

"ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН" АУДИТЫН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ

Огноо, дугаар	Байгууллага	Зөвлөмжийн утга	Албан шаардлагын утга	Биелэлт ирүүлсэн огноо, дугаар	Хариу тайлбар	Биелс эн эсэх
2022.06.02 A/12	НИТХ	1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн үр дүнд хяналтыг хэрэгжүүлж ажиллах.	байхгүй	2022.11.28 02/786	2022.08.18-ны өдрийн дүүргийн ИТХ-ын даргын 103 захирамжаар ИТХ-ын төлөөлөгчид дүүргүүдэд хуваарь гарган хөрөнгө оруулалтын ТАХ-ны явцын хяналтыг хийж ажилласан байна.	тийм
2022.06.02 A/12	БГД ИТХ		байхгүй	2022.11.22 02/346	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд дүүргийн ИТХ-ын Төсөв, санхүү, эдийн засгийн хороо хөндлөнгийн хяналт шалгалтын ажлыг хийж байна.	тийм
2022.06.02 A/12	БЗД ИТХ		байхгүй	2022.12.02 2/452	ИТХ-ын Төсөв, санхүү эдийн засгийн хороо, Дэд бүтэц, амьдрах орчны хөгжлийн хороо чиг үүргийн хүрээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавин ажиллаж байна. ИТХ-ын ээлжит хуралдаан 2022.12.09-16-ний хооронд хуралдах ба тус хуралдаанаар 2021, 2022 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ-ний гүйцэтгэл, санхүүжилтийн талаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Цаашид СС-ын 2021 оны 86 тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллана.	тийм
2022.06.02 A/12	БНД ИТХ		байхгүй	2022.11.18 02/232	2022.08.26-ны өдрийн дүүргийн ИТХ-ын ажлын хэсгийн тайлангаар ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажилд хяналт шалгалтыг хийж, ИТХ-ын 2022.08.29-ны 01/28 тоотор ДЗД-д чиглэл хүргүүлэн ажилласан байна.	тийм
2022.06.02 A/12	БХД ИТХ		байхгүй	2022.12.01 1/178	ДИТХ-ын 2020.12.09-ний өдрийн А/29 Тэргүүлэгчдийн тогтоолоор ажлын үйл явц, өмчийн бүртгэл, эзэмшил, ашиглалтад хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын хороог байгуулсан.Хөрөнгө оруулалтын ажилд тавих хяналтыг улирал тутам хуваарь гарган нийт 3 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. Ажлын явцын талаар ДИТХ-ын хороодод танилцуулан цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар зохих зөвлөмжийг гарган хяналт тавин ажилласан.	тийм
2022.06.02 A/12	НД ИТХ		байхгүй	2022.11.23 02/2074	ИТХ-ын зөвлөлийн 2022.05.17-ны 3 дугаар хуралдаан болон Төсөв, санхүү эдийн засгийн хурлын хорооны 2022.10.21-ны өдрийн 4 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжиж байгаа 18 ажил, он дамжин хэрэгжиж байгаа 10 ажилд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна.	тийм
2022.06.02 A/12	СБД ИТХ		байхгүй	2022.12.02 3/558	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх багийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2021.12.13-ны 37 тоот тогтоолоор шинэчлэн байгуулан ажиллаж байна. Тус баг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа ажилд хяналт тавьж, дүүргийн ИТХ-аар хэлэлцүүлж, ажилласан байна. 2021 онд ОНХС-н хөрөнгөөр хийгдсэн ажилд Б.Эрдэнэбулган ахлагчтай баг 2022.06.13-ны өдрийн ИТХ-ын хуралдаанд танилцуулсан байна.	тийм
2022.06.02 A/12	СХД ИТХ		байхгүй	2022.11.29 02/433	1. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу төсөл арга хэмжээний төлөвлөлтийг батлахдаа сайтар хянан ажиллаж байна. 2.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд дүүргийн ИТХ-ын Төсөв, санхүү, эдийн засгийн хороо хөндлөнгийн хяналт шалгалтын ажлыг хийж байна.	тийм
2022.06.02 A/12	ХУД ИТХ		байхгүй	2022.11.18 01/346	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд дүүргийн ИТХ нь хяналт шалгалтын ажлыг хийж байна.	тийм
2022.06.02 A/12	ЧД ИТХ		байхгүй	2022.11.22 2/500	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд дүүргийн ИТХ-ын Төсвийн зарцуулалтын хяналтын хороо хяналт шалгалтын ажлыг 4 дүгээр улиралд хийж байна.	тийм

2022.0 6.02 А/12	НЗДТГ	1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн үр дүнд хяналтыг хэрэгжүүлж ажиллах; 2. Хэрэгжиж дууссан ТАХ-г хууль, журамд заасан хугацаанд өмчийн хэлбэрийг тодорхой болгон бүртгэх; 3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах; 4. Өмнөх жилүүдийн аудитаар илэрсэн захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой алдаа зөрчлүүд арилахгүй давтагдаж, Төрийн аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй хууль, журмыг зөрчиж байгаа тул ЗДТГ, мэргэжлийн болон чиглэлийн байгууллага, нэгжийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, сахилга батыг дээшлүүлэх.	байхгүй	2022.11.28 03/6252	1.ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ТАХ-ний хэрэгжилтийг явцыг нийслэлийн удирдлагуудад танилцуулж, захиалагчийн хяналтыг тогтмол тавьж ажилласан. 2.ОНХС-ийн 2022 онд хэрэгжсэн нийт 9947.9 сая төгрөгийн үнийн дүнтэй 78 ТАХ-г нийслэлийн өмчид бүртгэн авч, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг нийслэлийн харьяа байгууллагуудад хариуцуулан ажиллалаа. 3.Нийслэлийн өмчид бүртгэгдсэн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хяналт тавих зорилгоор нийслэлийн харьяа 760 байгууллагатай "Өмчийг эзэмшүүлэх" гэрээ байгуулан ажилласан. 4. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гаргасан алдаа дутагдлыг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.	тийм
2022.0 6.02 А/12	БГД ЗДТГ		байхгүй	2022.11.22 05/2298	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилтийн үр дүнд хяналт тавьж, хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг өмчид бүртгэн ашиглагч байгууллагуудад хариуцуулан ажиллаж байна.	тийм
2022.0 6.02 А/12	БЗД ЗДТГ		байхгүй	2022.11.25 02/2733	Цаашид ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг зураг төсөвтэй батлуулахаар ажиллаж байна. Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн байна.	тийм
2022.0 6.02 А/12	БНД ЗДТГ		байхгүй	2022.11.18 03/409	1.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд төлөвлөж, санхүүжилт гүйцэтгэлийг ЗГ-ын 160 тогтоолыг баримтлан ажиллаж байна. 2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн нийтийн эзэмшлийн тохижилт,бүтээн байгуулалт эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг холбогдох данс бүртгэлд тусган ажиллаж байна. 3.ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг СӨХ, холбогдох байгууллагуудад хариуцуулан ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад анхааран ажиллах чиглэл өгөн ажиллаж байна. 4. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гаргасан алдаа дутагдлыг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.	тийм
2022.0 6.02 А/12	БХД ЗДТГ		байхгүй	2022.12.01 4/651	1.2021 онд нийт 228.7 сая төгрөгийн 9 ТАХ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 100 хэрэгжиж дууссан. 2.Тус ажлын гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлж, данс бүртгэлд 7 ТАХ-г бүртгэж, 2 ажлыг урсгал зардлаар бүртгэсэн. 3.ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг бүртгэн авсан байгууллага бүрэн хариуцан ажиллаж байна.	тийм
2022.0 6.02 А/12	НД ЗДТГ		байхгүй	2022.11.21 02/2054	1.2022 онд 30 ТАХ-г 1314.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлагдсанаас хэрэгжиж дууссан болон хэрэгжиж буй 20 ажилд 1040.9 сая санхүүжилтийг гүйцэтгэлтэй уялдуулан олгосон. 2.Хэрэгжүүлсэн ажлаас 21 ажлыг бүртгэн баталгаажуулахаас 12 ажлыг бүртгэлд тусгасан, 9 ажил дуусаагүй, 3 ажлыг өмчид бүртгэх боломжгүй тул зардлаар тусгасан. 3.ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг бүртгэн авсан байгууллага бүрэн хариуцан ажиллаж байна. 4.Захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой өмнөх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар анхааран ажиллаж байна.	тийм
2022.0 6.02 А/12	СБД ЗДТГ		байхгүй	2021.11.21 2107	1.ТАХ-ний төлөвлөлт, хэрэгжүүлэх явц, үр дүнд хяналт, шат шатны хариуцлагыг сайжруулах тал дээр анхааран ажиллаж байна. 2. Хэрэгжиж дууссан ТАХ-г хууль журманд заасан хугацаанд өмч данс бүртгэлдээ бүртгэн авах тал дээр анхааран ажиллаж байна.	тийм
2022.0 6.02 А/12	СХД ЗДТГ		байхгүй	2022.11.22 03/2695	1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилтийн үр дүнд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2.ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг тухай бүрд нь данс бүртгэлд бүртгэж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг бүртгэн авсан байгууллага бүрэн хариуцан ажиллаж байна.	тийм
2022.0 6.02 А/12	ХУД ЗДТГ		байхгүй	2022.11.23 06/2008	1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 8 ТАХ-нээс хэрэгжиж дууссан 1, хэрэгжих шатандаа байгаа 5, ХААА-ны шатанд байгаа 2 төсөл арга хэмжээ байна. Хэрэгжиж байгаа 5 ТАХ-нд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2.ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 2 ширхэг гүний худгийг өмчид бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хороодын засаг дарга нарт хүлээлгэн өгч ажиллаж байна.	тийм

2022.0 6.02 А/12	ЧД ЗДТГ	байхгүй	байхгүй	2022.11.21 3/2956	1.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх 19 ТАХ хэрэгжүүлэхээр холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд төлөвлөж, 2021.12.7-ны өдрийн ИТХ-ын тогтоолоор батлуулсан. 2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 553.3 сая төгрөгийн өртөг бүхий 12 нэр төрлийн хөрөнгийг ЗДТГ-ын даргын А/308 тушаалаар бүртгэн авч ажилласан. 3.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний явцад 2-3 удаа шалгаж, бий болсон хөрөнгийг СӨХ, холбогдох байгууллагуудад хариуцуулан ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад анхааран ажиллах чиглэл өгөн ажиллаж байна. 4. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гаргасан алдаа дутагдлыг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.	тийм
2022.0 6.06 527	БЗД ХААА	байхгүй	1.Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлж, шаардлагад нийцсэн гүйцэтгэгч сонгон шалгаруулах 2. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх явц, үр дүнд тавих хяналт, шат шатны хариуцлагыг сайжруулах	2022.11.18 859	Албан шаардлагын дагуу БЗД-ийн ХААА нь төлөвлөгөө боловсруулан тендерийн бичиг баримтуудад хяналт тавьж, дахин давуулахгүй байх тал дээр сургалт явуулан ажиллаж байна.	тийм
2022.0 6.06 525	БНД ХААА	байхгүй		2022.11.21 228	1. 2022.11.15-ны өдрийн байдлаар нийт 31 ТАХ цахимаар тендер шалгаруулан тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлж, шаардлагад нийцсэн компани сонгон шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлж ажиллаж байна. 2. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гаргасан алдаа дутагдлыг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.	тийм
2022.0 6.06 526	НД ХААА	байхгүй		2022.11.21 02/2054	1.Албаны дотоод аудитор 2022.06.15-ны өдөр 3 заалт бүхий зөвлөмж гарган, албаны албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. ҮХ-ны гишүүдийн боловсруулсан тендерийн баримт бичгийг боловсруулалтын шатанд хянаж, зөвлөмж өгсөн.	тийм
2022.0 6.06 523	ХУД ХААА	байхгүй		2022.11.18 537	Албан шаардлагын дагуу ҮХ-ны гишүүдэд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.1 заасны дагуу хянан үзэх шатны үнэлгээг чанартай хийх, дотоод хяналтыг сайжруулж ажиллах холбогдох заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.	тийм
2022.0 6.06 524	ЧД ХААА	байхгүй		2022.11.11 204	Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлж, шаардлагад нийцсэн гүйцэтгэгч сонгон шалгаруулж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан ажиллаж байна.	тийм
2022.0 6.06 522	НХОГ	байхгүй		2022.11.28 2/5113	Албан шаардлагын дагуу 5 ТАХ-ийн сонгон шалгаруулалттай холбоотой зөрчлүүдийг арилган, АЗ гэрчилгээ болон хурлын тэмдэглэл, хураангуй жагсаалт зэргийг архивын нэгжид тусад нь боть үүсгэн хадгалж ажилласан байна.	тийм
2022.0 6.06 528	УБ ЗАА	байхгүй		2022.11.28 01/1813	1.ТБОНӨХБАҮХАТХ-ийн хүрээнд тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичигт хяналт тавин, илэрсэн алдаа зөрчлийг дахин гаргахгүй ажиллахыг үүрэг чиглэл өгч ажиллаж байна. 2.Шилэн дансны системд ХАА-тай холбоотой мэдээллийг тухай бүр тайлагнан хариуцлагыг сайжруулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	тийм

Хавсралт 4

ХЭРЭГЖИЖ ДУУССАН БОЛОВЧ ӨМЧИД БҮРТГЭЭГҮЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

/сая.төг/

№	ТАХ-ний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг
1	Төв замаас хорооны шинэ сургуулийн автомашины зогсоол хүртэлх авто зам, 4 дүгээр хороо, 0.16 км	2023-2023	330.2
2	Төв замаас 134 дүгээр сургууль, 215 дугаар цэцэрлэгийн автомашины зогсоол хүртэлх авто зам, 24 дүгээр хороо, 0.318 км	2023-2023	508.3
3	Гэрэлтүүлэг, 33 дугаар хороо	2023-2023	270.5
4	Гэрэлтүүлэг, 41 дүгээр хороо	2023-2023	133.5
5	Гудамж талбайн камержуулалт хийх /4 дүгээр хороо/	2023-2023	47.0

6	Гудамж талбайн камержуулалт хийх /8 дугаар хороо/	2023-2023	53.0
7	Гудамж талбайн камержуулалт хийх /13 дугаар хороо/	2023-2023	15.2
8	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт /13 дугаар хороо/	2023-2023	29.2
9	Автомашины зогсоол байгуулах /17 дугаар хороо/	2023-2023	35.0
10	Гудамж талбайн камержуулалт хийх /23 дугаар хороо/	2023-2023	49.4
11	Явган хүний зам талбайн тохижилт /29 дүгээр хороо/	2023-2023	22.1
12	Сагсан бөмбөгийн талбай байгуулах /32 дугаар хороо/	2023-2023	64.1
13	Гудамж талбайн камержуулалт хийх /37 дугаар хороо/	2023-2023	40.3
14	Тохижилтын ажил /28 дугаар хороо/	2023-2023	37.5
15	Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг сайжруулах, эрчим хүчээр хангах ажил /Нарийн фермийн айл өрхийн гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил	2023-2023	56.2
Нийт			1,691.5